



АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Дарга, тэргүүлэх аудитор
Т.ОЮУНЧИМЭГ
Утас: 70592439

Аудитын менежер:
Х.НАРАНЦАЦРАЛ
Утас: 70592225

Ахлах аудитор:
Б.ГАНТУЯА

Аудитор:
Т.ОЮУН-ЭРДЭНЭ

Шинжээч:
Ж.УГТАХБАЯР
С.ЖАЛБАА

Утас: 70593113

АГУУЛГА

АУДИТЫН ТАЙЛАН.....	0
1 Аудитын гэрчилгээ	3
2 Аудитын тайлан	5
2.1 Оршил	5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7 Тогтоосон материаллаг байдлын түвшин	8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал.....	8
2.8.2 Авлагын бүртгэл, тайлагнал.....	10
2.8.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал	12
2.8.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал.....	14
2.8.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал:	15
2.8.6 Орлогын бүртгэл, тайлагнал	17
2.8.7 Зардлын бүртгэл, тайлагнал:	20
2.8.8 Эм эргэлтийн сангийн бүртгэл, тайлагнал:	23
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	24
2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	25
2.11 Шилэн дансны мэдээлэл.....	26
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	26
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	26

Товчилсон үгс

СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ОНТБ	Орон нутгийн төсвийн байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ҮХААЯ	Үйлдвэр хөдөө аж ахуйн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1 Аудитын гэрчилгээ



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08,
Факс: 70-59-24-39
E-mail: dundgovt@audit.gov.mn

2017.04.17 № 114
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын харьяа Дундговь аймгийн Аудитын газраас аудит хийв.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ОЮУНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит /ДУА-2017/1/СТА-ТЕЗ/ хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан заавар, журам, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсөв захирагч төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 17-ны хооронд хийж, аудитын тайланг 04 дүгээр сарын 18-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгч байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хэрэгжүүлэв.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч 2016 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангаа 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдөр төрийн аудитын байгууллагад /2017.03.31-ний өдрийн 1/348 дугаар албан бичгээр/ ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, гарын авлагын дагуу аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд /СТАУС/ оруулсан бөгөөд аудитад баримталсан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Санхүүгийн аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хэрэгжүүлж, үе шатны ажил тус бүрд чанарын хяналт хийж баталгаажуулсан.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд, УСНББОУС болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг шалгуур болгон ашиглав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад, дотоод орчны талаар ойлголт олж авахын тулд тухайн салбарт дагаж мөрддөг хууль, журмыг судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын зорилго: Дундговь аймгийн хөгжлийн төлөвлөгөө нь дараах зорилго, зорилтод чиглэгдэж байна. Үүнд:

- Аймгийн эдийн засаг, нийгмийг төр засгийн бодлогод нийцүүлэн уялдаа холбоог хангаж, тэнцвэртэй хөгжүүлэх
- Орон нутгийн онцлог байдалд тохирсон хөгжлийн хэтийн чиг хандлагыг тодорхойлох
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлж, байгаль орчны зохистой бодлого явуулснаар бизнес хөгжих таатай орчныг бүрдүүлэх
- Орон нутгийн нөөц, боломжид тулгуурласан жижиг дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх
- Уул уурхай, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг шинэ салбаруудыг хурдацтай хөгжүүлнэ гэж Дундговь аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөнд тусгажээ.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч төсөв захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэх” журам

Тайлант хугацаанд төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Их Хурлаас 47 дугаар тогтоолыг баталсан байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 133 төсөвт байгууллага, 189 төсөл сан, аймаг, сумдын 16 төрийн сан, 20-н ОНӨААТҮГ нийт 358 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төсөв захирагчийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд Сангийн яамны Э-тайлан санхүүгийн цахим программ хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар дараах маягтуудаар баримтжуулав.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх ойлголт болон цуглуулсан мэдээлэлд үндэслэн эрсдэлийн үнэлгээний горимоор 1 эрсдэлтэй асуудал тодорхойлж, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.2 маягтад нэгтгэн, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 3 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 Тогтоосон материаллаг байдлын түвшин

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 65,380.7 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 653.8 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 1 чиглэлээр 1 эрсдэлтэй асуудалд 1 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүнг /ТАБ-СТА-В-4.1/ маягтаар баримтжуулав.

Харин аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийг бага гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй, аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

2.8.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Төрийн сан дах харилцах дансны үлдэгдэл, ОНӨААТҮГ-ын арилжааны банкн дахь төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл,
- Кассад байгаа бэлэн мөнгө,
- Арилжааны банкуудад байршдаг орон нутгийн орлогын харилцах дансдын үлдэгдэл.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2016 оны эхэнд 3,251.5 сая төгрөг байсан бол оны эцэст 3,511.6 сая төгрөг болж 8.0 хувиар өсчээ. Нийт үлдэгдлийн 3.9 хувь буюу 138.1 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтцээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө	3.3	3.5	3.5		
- Төгрөг	3.3	3.5	3.5		
Банкинд байгаа бэлэн мөнгө	3,248.2	3,508.1	-	138.1	3,370.0
- Төрийн сангийн харилцах	3,119.3	3,370.0	-	-	3,370.0
- Арилжааны банк дахь харилцах	128.9	138.1	-	138.1	-
- Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.0	0.0	-	-	-
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	3,251.5	3,511.6	3.5	138.1	3,370.0

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал, жижиг мөнгөн сан 0.2 сая төгрөгөөр, банкинд байгаа бэлэн мөнгө 259.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Төрийн санд байршиж буй харилцах дансдын үлдэгдлийг сумд болон төрлөөр хураангуйлан харуулбал:

(сая төгрөгөөр)

№	Нэр	Харилцах дансны үлдэгдэл	Үүнээс:			
			Төсөл сан	Төсөвт байгууллага	Ерөнхий орлогын данс	ОНӨААТҮГ
1	Адаацаг	130.5	72.3	47.5	8.5	2.2
2	Баянжаргалан	206.1	90.7	95.7	16.8	2.9
3	Говь-Угтаал	134.1	116.6	11.0	6.5	0.03
4	Гурван сайхан	89.7	31.9	31.5	26.1	0.2
5	Дэлгэрцогт	71.4	31.5	27.2	12.7	0.02
6	Дэрэн	159.7	102.7	35.9	20	1.1
7	Дэлгэрхангай	71.5	59.5	-	5.2	6.8
8	Цагаандэлгэр	136.8	63.2	67.3	6.1	0.2
9	Өндөршил	162.5	89	55.7	17.8	0.03
10	Өлзийт	174.9	119.3	40.8	14.7	0.02
11	Сайхан-овоо	29.4	19.9	4.0	5.4	0.1
12	Сайнцагаан	316.1	238.3	52.4	25.4	0.01
13	Хулд	41.1	36	-	4.3	0.8
14	Луус	85.3	49.1	30.0	4.1	2.1
15	Эрдэнэдалай	148.5	73.8	64.6	9.8	0.05
16	ОНТБ-ууд	1,437.5	258.9	99.0	1079.8	
17	ОНӨААТҮГ-ууд	116.5				116.5
Дүн		3,511.6	1,452.7	662.6	1,263.2	133.1

Нийт мөнгөн хөрөнгийн 54.8 хувийг төсвийн байгууллагуудын, 3.8 хувийг ОНӨААТҮГ-уудын, 41.4 хувийг төсөл сангийн мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна.

2.8.2 Авлагын бүртгэл, тайлагнал

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 7,002.6 сая төгрөг байсан бол оны эцэст 8,631.7 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:

/сая төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он	Өсөлт / (Бууралт)	Эзлэх хувь /2016/
Ажиллагчидтай холбогдсон авлага	14.8	8.9	(5.9)	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	25.2	14.8	(10.4)	0.2
Зээлийн хүүгийн авлага	11.4	82.2	70.8	1.0
Дансны авлага /ОНӨҮГ/	77.6	90.3	12.7	1.0
Татвар, НДШ-авлага /ОНӨҮГ/	1.3	0.7	(0.6)	0.0
Байгууллагаас авах авлага	3,769.5	1,335.7	(2,433.8)	15.5
Хувь хүмүүсээс авах авлага	3,097.6	2,125.9	(971.7)	24.6
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	5.2	4,084.6	4,079.4	47.3
Хувь хүмүүст олгосон зээл	0	658.8	658.8	7.6
Хувийн хэвшлийн ААН-д олгосон зээл	0	229.8	229.8	2.7
Нийт дүн	7,002.6	8,631.7	1,629.1	100.0

Дээрх судалгаанаас харахад тайлант оны авлагын үлдэгдэл өмнөх оноос 1,629.1 сая төгрөгөөр буюу 23.3 хувиар өссөн харагдаж байгаа боловч нийт 2,450.3 сая төгрөгөөр бууржээ.

Энэ нь Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон авлагын эхний үлдэгдэл 4,084.6 сая төгрөгийг тохируулан устгах бичилт хийж 5.2 сая төгрөгөөр тайлагнасан буюу тайлант оны хорогдсон авлагыг 4,079.4 сая төгрөгөөр сөрөг тохируулан тайлагнасантай холбоотой байна. Үүнээс үзэхэд устгах бичилтийн нөлөөллийг эс тооцвол авлага буурсан байна.

Устгах бичилт нь УСНББОУС 6 дугаар стандарт Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн 46-д /Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх байгууллагуудын хоорондын тооцооны үлдэгдэл, ажил гүйлгээ буюу төстэй хуваарилалтыг хамруулах бөгөөд тэдгээрийг бүрэн устгана/ заасны дагуу хийгджээ.

Нийт авлагын 47.3 хувийг Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн авлага, 50.4 хувийг сум хөгжүүлэх сангийн авлага /байгууллагаас авах авлага, хувь хүмүүсээс авах авлага, хувийн хэвшлийн ААНБ-д олгосон зээл, хувь хүмүүст олгосон зээл/ 2.7 хувийг бусад авлага тус тус эзэлж байна.

Тайлант онд хувийн хэвшлийн ААНБ-д олгосон, хувь хүмүүст олгосон зээл гэсэн авлагууд шинээр нэмэгдсэн нь зарим сумд сум хөгжүүлэх сангийн авлагыг салгаж бүртгэсэнтэй холбоотой байна.


Авлагын үлдэгдэл, өсөлт, бууралтыг төсвийн захирагч тус бүрээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Төсөв захирагч	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
ОНТБ, ОНӨААТҮГ	3,076.4	4,970.4	1,893.9	57.6
Дэлгэрцогт	178.5	173.8	(4.7)	2.0
Дэрэн	260.3	183.8	(76.5)	2.1
Говь-Угтаал	132.0	112.1	(19.8)	1.3
Цагаандэлгэр	158.7	186.3	27.7	2.2
Баянжаргалан	221.4	204.3	(17.1)	2.4
Өндөршил	138.3	133.6	(4.7)	1.5
Гурвансайхан	253.3	245.3	(8.0)	2.8
Өлзийт	175.5	180.4	4.9	2.1
Хулд	188.3	183.3	(5.0)	2.1
Луус	168.3	170.1	1.8	2.0
Дэлгэрхангай	224.1	212.6	(11.5)	2.5
Сайхан-Овоо	234.3	220.3	(14.0)	2.6
Эрдэнэдалай	381.1	381.6	0.5	4.4
Сайнцагаан	975.0	886.9	(88.1)	10.3
Адаацаг	237.1	186.8	(50.2)	2.2
Нийт дүн	7,002.6	8,631.8	1,629.19	100.00

Нийт авлагын 42.4 хувийг сумдын төсөвт байгууллагын авлага, 57.6 хувийг ОНӨААТҮГ-ууд болон аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагууд эзэлж байна.

Авлагыг насжилтаар нь судлаж үзвэл 2007 оноос өмнө үүссэн 2,231.2 сая, 2007 оноос 2009 онуудад нэмэгдсэн 4.5 сая, 2010 оноос 2012 онуудад нэмэгдсэн 334.4 сая, 2013 оноос 2015 онуудад нэмэгдсэн 4,300.9 сая, 2016 онд шинээр нэмэгдсэн 1,760.8 сая төгрөгийн авлага байна.



Авлагын насжилтыг хувиар илэрхийлбэл нийт авлагын 26 хувь нь 120 сараас дээш, 4 хувь нь 84 сараас 84 сарын, 50 хувь нь 12 сараас 48 сарын, 20 хувь нь 1 сараас 12 сарын насжилттай байна.

Өндөр буюу 120 сараас дээш насжилттай авлагын 98.5 хувь нь Дундговь Ус ОНӨААТҮГ-ын “Хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-ийн авлага, 12-48 сарын насжилттай авлагын 43.9

хувийг Гурвансайхан сумын ЗДТГ-ын “Хот байгуулалтын салбарын төсөл”-ийн авлага тус тус эзэлж байна.

Нийт авлагын 50.4 хувь нь Сум хөгжүүлэх сангаас төсөл хэрэгжүүлэгч ААНБ болон иргэдэд олгосон зээл эзэлж байгаа ба сумд хугацаа хэтэрсэн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Авлагатай холбоотой илэрсэн зөрчлүүдийн талаар:

Авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, бүртгэлийг аккрузал сууриар бүртгээгүй зэрэг нийтлэг алдаа зөрчлүүд илэрснээс гадна насжилт өндөртэй авлагын дүн өндөр байна. Энэ нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д /Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө/ 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, 20.2.6-д /Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах/, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/ заасныг тус тус зөрчиж байна.

Дээрх алдаа зөрчлүүд нь холбогдох стандарт, хууль, дүрэм, журам зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, найдваргүй авлага өсөх, зээлийн эргэн төлөлт хугацаандаа төвлөрөөгүйгээс Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэр дутагдах, хөрөнгийн хүртээмж, үр ашиг буурах сөрөг үр дагаваруудыг бий болгож байна.

Цаашид УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, тэдгээртэй холбогдон гарсан журмуудыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

2.8.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 5,179.3 сая төгрөг байсан бол жилийн эцэст 5,503.5 сая төгрөг болж 324.2 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын бүтцийг харуулбал:

(сая.төгрөгөөр)

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, (бууралт)
Тусгай зориулалтын материал	1,153.4	1,324.4	171.0
Эм боох материал	146.4	126.0	(20.4)
Бэлэн бүтээгдэхүүн	0.7	10.9	10.2
Бичиг хэргийн материал	142.2	189.2	47.0
Аж ахуйн материал	1,520.8	1,515.9	(4.9)
Сэлбэг хэрэгсэл	42.3	41.5	(0.8)
Түлш шатахуун, тослох материал	110.7	125.0	14.3
Барилга засварын материал	121.8	238.2	116.4
Хүнсний материал	87.9	137.4	49.5
Бусад хангамжийн материал	705.0	685.8	(19.2)
Мал амьтад	1,108.9	1,099.2	(9.7)
Нөөцийн бараа	39.2	10.0	(29.2)
Нийт дүн	5,179.3	5,503.5	324.2

Бараа материалын өсөлтийг нэр төрлөөр нь авч үзвэл сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материал, мал амьтад, эм боох материал, бусад хангамжийн материал, нөөцийн бараа 0.8-29.2 хувиар буурсан бол тусгай зориулалтын материал, бэлэн бүтээгдэхүүн, бичиг хэргийн материал, түлш шатахуун, тослох материал, барилга засварын материал, хүнсний материал 10.2-171.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бараа материалын үлдэгдлийг нийт дүнд эзлэх хувиар харуулбал:



Нийт бараа материалын үлдэгдлийн 431.1 сая төгрөг буюу 7.8 хувийг ОНӨААТҮГ-уудын бараа материалын үлдэгдэл эзэлж байна.

Бараа материалтай холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар бараа материалтай холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Хүнсний материалын зарцуулалтыг орцын нормоор хянаагүй;
- Гадны тээврийн хэрэгслээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй; үр дүнг тооцоогүй, хяналтгүй зарцуулсан;
- Шатахууныг хөрөнгийн дансаар дамжуулаагүй шууд зардалд тайлагнасан;
- Шатахуун зарцуулалтын тооцоо алдаатай, тооцоо бодож байгаа анхан шатны баримт зөрүүтэй, бүрдэл дутуу;
- Хяналтын тооллогоор хөрөнгө дутагдсан, хөрөнгийн ашиглалт, хадгалалтанд тавих дотоодын хяналт хангалтгүй;
- Хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй.

Харин Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг нь хүүхдийн хүнсний хэрэгцээнд 6 толгой малыг мал амьтад данснаас хассан боловч хүнсний материалын дансаар дамжуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулж, тушаал шийдвэрийг нөхөж гаргасан зөрчил илэрсэн.

Дээрх алдаа зөрчлүүд нь холбогдох стандарт, хууль, дүрэм, журам зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, ажлын хариуцлага, дотоод хяналт сулрах, хөрөнгө дутагдах, үрэгдэх зэрэг сөрөг үр дагаваруудыг бий болгож байна.

Цаашид УСНББОУС-12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, эдгээртэй холбогдон гарсан журмуудыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

2.8.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгө 2016 оны эхэнд 127,532.6 сая төгрөг байсан бол тайлангийн хугацаанд 9.7 хувь буюу 12,449.3 сая төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 139,981.9 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)


№	Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн +/-, буурсан -/-
1	Барилга байгууламж	101,488.4	114,609.2	13,120.8
2	Тээврийн хэрэгсэл	4,406.2	4,742.5	336.3
3	Машин тоног төхөөрөмж	8,418.7	8,583.4	164.7
4	Тавилга эд хогшил	4,475.9	4,196.0	(279.9)
5	Дуусаагүй барилга	4,352.9	3,130.9	(1,222.0)
6	Зам, гүүрийн байгууламж	22.9	22.9	-
7	Батлан хамгаалах тоног төхөөрөмж	5.6	5.6	-
8	Түүх соёлын дурсгалт зүйл	857.4	881.3	23.9
9	Номын фонд	504.2	520.4	16.2
10	Биет бус хөрөнгө	137.9	151.9	14.0
11	Бусад үндсэн хөрөнгө	2,862.5	3,137.8	275.4
	Дүн	127,532.6	139,981.9	12,449.3

Нийт үндсэн хөрөнгийн 81.8 хувийг барилга байгууламж, 3.4 хувийг тавилга, эд хогшил, 6.1 хувийг машин тоног төхөөрөмж, 2.2 хувийг дуусаагүй барилга, 3.4 хувийг тээврийн хэрэгсэл, 2.4 хувийг бусад үндсэн хөрөнгө, 0.6 хувийг түүх соёлын дурсгалт зүйл, үлдсэн 0.1 хувийг номын фонд, батлан хамгаалах тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө, зам гүүрийн байгууламж тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 15,815.3 сая төгрөгөөр /үүнээс худалдан авсан 234.7, хандив тусламжаар 10,341.4 сая, шилжүүлж авсан 4,130.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр 66.2 сая, бусад 1,042.7 сая/ нэмэгдэн, 3,365.9 сая төгрөгөөр /үүнээс худалдсан 50.9 сая, акталсан 568.4 сая, шилжүүлсэн 1,203.0 сая, бүтцийн өөрчлөлтөөр 63.3 сая, бусад 1,480.3 сая,/ хасагдсан, тайлант онд нийт 5,290.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тайлант онд барилга байгууламж 13,120.8 сая, тээврийн хэрэгсэл 336.3 сая, бусад үндсэн хөрөнгө 275.4 сая, машин тоног төхөөрөмж 164.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн бүтцийг диаграммаар харуулбал:



Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

Аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Хөрөнгийг анх олж бэлтгэхдээ санхүүгийн тайланд буруу ангилан бүртгэсэн;
- Цагаандэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв барилгын их засварыг орлогоор хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд тайлагнасан;
- Өлзийт сумын Цэцэрлэг, Цагаандэлгэр сумын Цэцэрлэг, Засаг даргын Тамгын газар өөрийн барилгад их засвар хийхдээ барилгын өөрийн өртөгт нэмж капиталжуулаагүй;
- Завсрын аудитын хяналтын тооллогоор хөрөнгө дутагдуулсан. Тухайлбал Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төв, Засаг даргын Тамгын газар, Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төв, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй тайлагнасан;
- Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй авсан орлого тодруулга тайлангаас зөрүүтэй тайлагнагдсан байна.

Хөрөнгө дутагдсан, ангилал буруу бүртгэсэн, элэгдлийн зардал буруу тооцогдсон зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлан, тодруулга, тайлант үеийн үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайлан буруу илэрхийлэгдэх материаллаг нөлөөтэй эрсдэлийг үүсгэх тул хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах, тооллогыг чанартай зохион байгуулах, үндсэн хөрөнгийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл болон гарсан зөрүүг холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлж нягтлан бодох бүртгэлд тусгаж байх нь зүйтэй.

2.8.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал:

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өр төлбөрийн эхний үлдэгдэл 4,880.3 сая төгрөг, тайлант хугацаанд 4,137.0 сая төгрөгөөр өсч, оны эцэст 9,017.3 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	4,079.4	0	(4,079.4)
Ажилчидтай холбогдсон өглөг	13.8	11.0	(2.8)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	63.6	24.2	(39.4)

Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	0.4		(0.4)
Байгууллагад төлөх өглөг	611.4	746.3	134.9
Хувь хүмүүст төлөх өглөг	2.6	1.8	(0.8)
Татварын өр	11.8	13.2	1.4
НДШ-ийн өглөг	0.3	0.1	(0.2)
Дансны өглөг	97.0	61.9	(35.1)
Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,880.3	858.5	(4,021.8)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн өр	0	8,158.8	8,158.8
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0	8,158.8	8,158.8
Нийт өр төлбөрийн дүн	4,880.3	9,017.3	4,137.0

Дээрх хүснэгтээс харахад өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 4,137.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь “Дундговь-Ус” ОНӨААТҮГ, Гурвансайхан сумын ЗДТГ-ын 4,079.4 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг урт хугацаат өр төлбөрт шилжүүлэн бүртгэхдээ устгах бичилт хийгээгүйгээс 8,158.8 сая төгрөгөөр буюу давхар тайлагнагдсан байна.

Өр төлбөрийн үлдэгдлийг сум, тус бүрээр харуулбал:

/сая төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Нийт өр төлбөр		Өсөлт, (бууралт)
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	Дэлгэрцогт	18.7	2.0	(16.7)
2	Дэрэн	26.5	26.8	0.3
3	Говь-Угтаал	17.9	8.8	(9.1)
4	Цагаандэлгэр	14.7	10.8	(3.9)
5	Баянжаргалан	20.4	18.6	(1.8)
6	Өндөршил	11.8	14.6	2.8
7	Гурвансайхан	1,897.5	10.8	(1,886.7)
8	Өлзийт	26.9	14.0	(12.9)
9	Хулд	35.4	10.8	(24.6)
10	Луус	24.0	7.3	(16.7)
11	Дэлгэрхангай	3.0	4.8	1.8
12	Сайхан-Овоо	6.2	3.4	(2.8)
13	Эрдэнэдалай	127.6	18.1	(109.5)
14	Сайнцагаан	3.2	0.4	(2.8)
15	Адаацаг	17.4	7.7	(9.7)
16	ОНТБ, ОНӨААТҮГ	2,629.1	8,858.4	6,229.3
	Дүн	4,880.3	9,017.3	4,137.0

Нийт өрийн 98.2 хувийг аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагууд, ОНӨААТҮГ-уудын, 1.8 хувийг сумдын төсвийн байгууллагуудын өр төлбөр тус тус эзэлж байна.

Аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагууд болон ОНӨААТҮГ-уудын өр төлбөрийн 92.1 хувийг аймгийн ЗДТГ, Гурвансайхан сум, Дундговь Ус ОНӨААТҮГ-ын төслийн өр төлбөр эзэлж байна.



2.8.6 Орлогын бүртгэл, тайлагнал

2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үйл ажиллагааны орлогын нийт дүн 68,467.7 сая төгрөг байгаа нь өмнөх 2 оны мөн үетэй харьцуулахад 2014 оноос 19,386.2 сая төгрөг, 2015 оноос 12,135.5 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	Зөрүү 2014/2016	Зөрүү 2015/2016
Татварын орлого	3,700.8	4,008.8	4,327.3	626.5	318.5
Татварын бус орлого	32,766.5	31,553.0	20,761.2	(12,005.3)	(10,791.8)
Тусламж санхүүжилтийн орлого	51,386.6	45,041.4	43,379.1	(8,007.5)	(1,662.3)
Үйл ажиллагааны орлогын дүн	87,853.9	80,603.2	68,467.6	(19,386.3)	(12,135.4)

Дээрх хүснэгтээс харахад татварын орлого өмнөх оноос 318.5 сая төгрөгөөр өссөн бол татварын бус орлого 10,791.7 сая төгрөгөөр, тусламж санхүүжилтийн орлого 1,662.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Орлого буурсан шалтгаан нь өмнөх оноос үнэ төлбөргүй орлого 53.9 хувь, хөрөнгийн санхүүжилт 50.1 хувиар тус тус буурсантай холбоотой байна.

Орлогын үзүүлэлтүүдийг сүүлийн 3 оноор харьцуулан харуулбал:



Судалгаанаас харахад 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 4,327.3 сая төгрөг буюу 6.3 хувийг татварын орлого, 20,761.2 сая төгрөг буюу 30.3 хувийг татварын бус орлого, 43,379.1 сая төгрөг буюу 63.4 хувийг тусламж санхүүжилтын орлого эзэлж байна.

Татварын орлогын биелэлтийг нэр төрлөөр нь харуулбал:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого	3,393.0	3,266.8	(126.2)
Үйл ажиллагааны орлого	312.8	407.7	94.9
Хөрөнгө борлуулсны орлого	60.0	124.2	64.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(430.2)	(430.2)	0.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	75.0	84.3	9.3
Бууны албан татвар	21.7	17.7	(4.0)
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	200.0	204.9	4.9
Улсын тэмдэгтийн хураамж	85.0	97.4	12.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	45.0	30.6	(14.4)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	35.0	19.6	(15.4)
Газрын төлбөр	180.0	171.2	(8.8)
Дуудлага худалдаа	50.0	58.1	8.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	141.4	216.9	75.5
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	40.0	30.0	(10.0)
Бусад татвар	35.0	28.1	(6.9)
Татварын орлого	4,243.7	4,327.3	83.6

Тайлант хугацаанд 4,243.7 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,327.3 сая төгрөгийн орлого төвлөрч 83.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн боловч орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого, бууны албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын төлбөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөр, бусад татвар тус тус тасарсан байна.

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлогын төлөвлөгөөг 3,393.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,266.8 сая төгрөг төвлөрүүлж, 126.2 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь цалин, хөлс нэмэх талаар шийдвэр гараагүй байхад өмнөх оноос төлөвлөгөөг 521.7 сая төгрөгөөр нэмж баталсантай холбоотой байна,
- Бууны албан татварыг 21.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 17.7 сая төгрөг төвлөрүүлж, 4.0 сая төгрөгөөр тасарсан. Тайлант онд Галт зэвсгийн албан татварын тухай хууль шинээр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус орлогыг өндөр төлөвлөсөн бөгөөд Цагдаагийн газарт бүртгэлтэй буу цөөн, галт зэвсгийн үзлэг явагдаж зөрчилтэй буунуудыг улсын орлого болгосонтой холбоотойгоор төлөвлөгөө тасарсан,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 35.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 19.6 сая төгрөг төвлөрүүлж, 15.4 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь аймаг, сумын удирдлагууд хуулинд заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй, орлого бүрдүүлэхэд санаачилга гаргаагүйтэй холбоотой байна. Үүнээс Сайнцагаан сум тус орлогыг 18.1 сая төгрөгөөр тасалсан нь нөлөөлжээ.

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 45.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 30.6 сая төгрөг төвлөрүүлж, 14.4 сая төгрөгөөр тасарсан. Улсын чанартай автозамын ажил дууссан боловч төлөвлөгөөг хасч батлаагүйтэй холбоотойгоор энэ орлого тасарчээ,
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 10.0 сая төгрөгөөр, газрын төлбөр 8.8 сая төгрөгөөр тус тус тасарсан нь аймгийн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсонтой холбоотой байна.

Үйл ажиллагааны орлогыг төсвийн захирагчаар харуулбал:

/сая төгрөгөөр/

Байгууллага	Татварын орлого	Татварын бус орлого	Тусламж санхүүжилтийн орлого	Дүн
ОНӨААТҮГ, ОНТБ	3,479.5	11,545.4	12,374.3	27,399.2
Дэлгэрцогт	15.9	206.6	1,446.9	1,669.5
Дэрэн	75.3	831.1	1,538.2	2,444.5
Говь-Угтаал	19.5	230.9	1,173.6	1,424.0
Цагаандэлгэр	51.7	268.0	1,270.4	1,590.2
Баянжаргалан	43.5	188.5	1,415.4	1,647.3
Өндөршил	51.2	457.2	1,452.5	1,960.8
Гурвансайхан	73.5	2,383.3	1,692.0	4,148.8
Өлзийт	66.8	484.1	1,668.4	2,219.3
Хулд	53.3	665.7	1,498.1	2,217.0
Луус	21.3	153.2	1,389.0	1,563.5
Дэлгэрхангай	17.0	1,050.4	1,835.3	2,902.8
Сайхан-Овоо	19.1	394.3	1,645.2	2,058.5
Эрдэнэдалай	57.9	287.1	2,563.5	2,908.5
Сайнцагаан	252.5	1,322.3	8,733.7	10,308.5
Адаацаг	29.2	293.4	1,682.8	2,005.4
Нийт дүн	4,327.3	20,761.2	43,379.1	68,467.7

Орлоготой холбоотой илэрсэн зөрчлүүдийн талаар:

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд төсөвт байгууллагын өөрийн орлогыг бүртгээгүй, харилцах дансанд бүрэн төвлөрүүлээгүй, шийдвэргүй зарцуулсан, зарцуулалтын тайлан гаргаагүй, түрээсийн орлогын 20 хувийг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрлээ. Эдгээр зөрчил нь дараах хууль, журмыг зөрчсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д /Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө/, 14.4-т /нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, мөн хуулийн 14.4.1-т /аж ахуйн бүх ажил, гүйлгээ/, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6-д /Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа /бусад орлого/-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дах

бүртгэлийн дансанд тушаана/, Аймгийн Засаг даргын 2009 оны 3 дугаар сарын 10 өдрийн 97 дугаар захирамжаар батлагдсан “Үнэт цаас, тасалбарын маягт хэвлүүлэх, бүртгэх, зарцуулах журам”-ын 1.3 /Үнэт цаас, тасалбарын маягтын зарцуулалт, тайлагнал/, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 2.7-д /Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэгч хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 80 хувийг байгууллагын өөрийн орлогод төвлөрүүлж, барилга байгууламжийн засвар, үндсэн хөрөнгө худалдан авах зардалд зарцуулж болно. Тус орлогын 20 хувийг төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ/ заасныг тус тус зөрчсөн байна.

2.8.7 Зардлын бүртгэл, тайлагнал:

Зардлын бүтцийн талаар

Тайлант онд ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 64,341.1 сая төгрөгийн зарцуулалттай тайлагнагдсан нь өмнөх оноос 298.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ТЕЗ-ийн 2016 оны нийт зардлыг сумдаар харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Сумын нэр	Өмнөх он	Тайлант он	Өссөн/ (буурсан)	Тайлант оны зардалд эзлэх хувь
1	Дэлгэрцогт	1,587.6	1,618.7	31.1	2.5
2	Дэрэн	1,670.6	1,808.5	137.9	2.8
3	Говь-Угтаал	1,464.1	1,424.2	(39.9)	2.2
4	Цагаандэлгэр	1,347.9	1,501.1	153.2	2.3
5	Баянжаргалан	1,686.1	1,597.6	(88.5)	2.5
6	Өндөршил	1,597.7	1,636.2	38.5	2.5
7	Гурвансайхан	2,704.1	2,159.3	(544.8)	3.4
8	Өлзийт	1,742.5	2,136.7	394.2	3.3
9	Хулд	2,025.4	1,766.6	(258.8)	2.7
10	Луус	1,515.6	1,571.5	55.9	2.4
11	Дэлгэрхангай	1,969.5	2,087.2	117.7	3.2
12	Сайхан-Овоо	1,861.9	1,950.6	88.7	3.0
13	Эрдэнэдалай	3,088.2	2,754.6	(333.6)	4.3
14	Сайнцагаан	9,169.9	9,941.9	772.0	15.5
15	Адаацаг	1,983.8	1,877.1	(106.7)	2.9
16	Төрийн сан	28,628.2	28,509.3	(118.9)	44.3
Нийт дүн		64,043.1	64,341.1	298.0	100.0

Зардлын дүн өмнөх оноос нийт дүнгээрээ 298.0 сая төгрөгөөр өссөн бол Говь-Угтаал, Баянжаргалан, Гурвансайхан, Хулд, Эрдэнэдалай, Адаацаг сумд 39.9-544.8 сая төгрөгөөр буурсан, бусад сумд 31.1-772.0 сая төгрөгөөр өсчээ.



Дээрх диаграмаас харахад нийт зардлын 18,300.1 сая төгрөг буюу 29.0 хувийг цалин, 1,997.3 сая төгрөг буюу 3.0 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 3,239.9 сая төгрөг буюу 5.0 хувийг байр ашиглалтын тогтмол зардал, 10,002.9 сая төгрөг буюу 16.0 хувийг хангамж, бараа материалын зардал, 1,320.3 сая төгрөг буюу 2.0 хувийг нормативт зардал, 1,635.0 сая төгрөг буюу 3.0 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, 15,295.1 сая төгрөг буюу 24.0 хувийг сумдад олгох татаас санхүүжилт, 12,123.1 сая төгрөг буюу 11.0 хувийг бусад зардал, 7.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан байна.

Зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд зардлын данстай холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Ажиллагсадтай холбогдсон:

- Цалин, нэмэгдлийг буруу тогтоосон, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулж олгосон;
- Ажилтан албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй буюу буруу тооцож олгосон ;
- Ээлжийн амралтыг, цалин, жирэмсэн амаржсаны амралттай давхардуулан олгосон;
- Гадны байгууллагын ажилтан, иргэнд төсвөөс томилолт олгосон;
- Төрийн үйлчилгээний албан хаагч нарт урамшууллыг буруу үндэслэлээр олгосон.

Анхан шатны баримттай холбоотой:

- Хүчин төгөлдөр бус, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн;
- Анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийсэн;
- Засвартай баримтаар гүйлгээ хийсэн;
- Төсөв хөрөнгө зарцуулахдаа хамааралгүй буюу хүчингүй болсон хуулийн заалт, журам үндэслэн тушаал шийдвэр гаргасан.

Бүртгэл тооцоололтой холбоотой:

- Ээлжийн амралтын цалинг тооцохдоо цалингийн дунджийг буруу тооцоолох, өөр өөр аргачлал хэрэглэснээс зөрүү үүссэн;
- Шатахуун, худалдаж авсан нормын хувцас зэрэг зарим хөрөнгийг хөрөнгийн дансанд орлогодож авалгүй шууд зардалд тайлагнасан;
- Журналын бичилтийг буруу хийснээс санхүүгийн тайлан, тодруулга буруу илэрхийлэгдсэн.

Эдгээр зөрчлүүд нь дараах хууль журмуудыг зөрчиж байна. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д */Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/*, 14.3.1-т */анхан шатны баримт бүрдүүлэх/*, 13.7-д */13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/*;Төсвийн тухай хуулийн 6.4.1-т */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах /*;Хөдөлмөрийн тухай хуулийн 28.1-д */Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно/*; Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2010 оны 8 сарын 16-ны өдрийн 362/112/183 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6-д */Багш, ажилтны ур чадварыг үнэлэхдээ дараах тусгай шалгуур үзүүлэлтийг баримтлана/*;Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”;Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 */хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх/*

Анхаарал хандуулахуйц бусад зөрчлүүд:

Дээрх нийтлэг алдаа зөрчлөөс гадна УИХ-ын 2016 оны 09 сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтыг тус тус зөрчиж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиг багатай, хяналтгүй зарцуулсан дараах зөрчлүүд илэрлээ.Тухайлбал:

- Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль багш ажилчдад эрүүл мэндийн урьдчилсан шинжилгээнд хамрагдахад зориулж үндсэн цалингаас 0.9 сая төгрөгийн хөнгөлөлт олгосон;
- Төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баярын үйл ажиллагаа зохион байгуулж Адаацаг сумын Засаг даргын Тамгын газар 0.7 сая, Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газар 3.4 сая, Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар 0.2 сая, Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газар 0.2 сая, Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургууль 0.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Гурвансайхан сум Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөс Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд 9.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер нар хяналт тавих албан тушаалыг буюу өвчтэй, чөлөөтэй ажилтны үүргийг хавсран гүйцэтгэж, 1.9 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг ажилтны цалинтай давхардуулж авсан;

- Төсвийн хөрөнгөөр аялал зохион байгуулж Сайнцагаан сумын 4-р сургууль 1.4 сая, Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газар 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Эрдэнэдалай сум Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Засаг даргын Тамгын газарт тоног төхөөрөмж худалдан авсан;
- Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газар багийн даргаар ажиллаж байгаад ИТХ-ын даргаар томилогдсон хоёр байгууллагын төсвөөс 0.9 сая төгрөгийн цалин давхардуулж олгосон;
- Хөдөөгийн багш нарын спортын их наадамд Сайнцагаан сумын 3-р сургууль, Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль төсвөөс тус бүр 0.2 сая төгрөгийг зарцуулсан;
- Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь Засаг даргын нөөцөөс шийдвэргүй, гэрээ дүгнэсэн акт баримтгүйгээр АШУҮИС-ийн оюутны сургалтын төлбөрт 0.5 сая төгрөг төлсөн.

Эдгээр зөрчлүүд нь дараах хууль тогтоомжуудыг зөрчсөн байна. Үүнд:

Төсвийн тухай хуулийн 6.4.1-т */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах /*, 16.5.5-д */батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/* ; МУИХ-ын 2016 өдрийн 09 сарын 09-ны өдрийн 47 дугаар тогтоол */баталсан төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах/-ын 5-д /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/* заасныг тус тус зөрчсөн,

Дээрх алдаа зөрчлүүд нь холбогдох байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнууд болон дотоод хяналтын ажилтнуудын ажлын хариуцлагаас шалтгаалсан бөгөөд Санхүүгийн тайлан тодруулгууд буруу илэрхийлэгдэх, тооцооны зөрүүгээс өр авлага үүсэх, төсөв хяналтгүй үрэлгэн зарцуулагдах, ажлын хариуцлага сулрах эрсдэлийг бий болгож байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

2.8.8 Эм эргэлтийн сангийн бүртгэл, тайлагнал:

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд сумдын Эмийн эргэлтийн сангийн 15 тайлан нэгтгэгдсэнийг Саруул Баян-Уул аудит ХХК гэрээгээр аудит хийж, 15 санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Эмийн эргэлтийн сангууд нийт 47.4 сая төгрөгийн авлагын, 81.9 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй бөгөөд энэ нь эм боох материалын тооцоотой холбоотойгоор үүссэн байна.

Тайлант хугацаанд эм эргэлтийн сангууд нийт 805.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 770.2 сая төгрөгийн зарлагатай, 35.6 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

Үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

/Сая төгрөгөөр/

№	Сумдын нэрс	Нийт орлого	Нийт зардал	Үүнээс		Бусад зардал	Ашиг +/- алдагдал +/-
				Цалин, НДШ	Эмийн зардал		
1	Дэлгэрцогт	53.4	51.3	9.7	38.9	2.7	2.1
2	Дэрэн	66.3	60.5	7.0	49.1	4.3	5.8
3	Говь-Угтаал	49.9	49.6	8.5	38.5	2.5	0.4
4	Цагаандэлгэр	10.9	15.9	2.1	9.4	4.4	(5.0)
5	Баянжаргалан	33.4	28.7	1.7	24.3	2.6	4.7
6	Өндөршил	61.3	61.3	11.5	35.0	14.9	0.0
7	Гурвансайхан	52.8	49.6	8.8	36.3	4.4	3.2
8	Өлзийт	47.8	47.1	9.5	31.4	6.3	0.7
9	Хулд	56.1	55.8	8.8	43.5	3.4	0.3
10	Луус	53.8	49.7	9.9	32.9	6.8	4.1
11	Дэлгэрхангай	82.4	76.6	10.7	57.6	8.4	5.8
12	Сайхан-Овоо	49.1	44.6	5.8	34.4	4.4	4.4
13	Эрдэнэдалай	83.1	74.2	9.9	61.6	2.6	8.9
14	Сайнцагаан	36.7	38.6	6.8	30.3	1.5	(1.9)
15	Адаацаг	68.7	66.7	7.4	52.9	6.3	2.1
Нийт дүн		805.8	770.2	118.3	576.1	75.7	35.6

Нийт 770.2 сая төгрөгийн зардал гарснаас 15.3 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 71.4 хувийг эм, барааны, 13.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан байна.

Нийт дүнгээрээ 35.6 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч Цагаандэлгэр, Сайнцагаан сумдын Эмийн эргэлтийн сангууд 1.9-5.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

2.9 АУДИТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ, ГАРГАСАН ШИЙДЭЛ

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Харин 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайлан, тодруулга дахь алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

Аудитаар нийт 6,092.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж аудитын явцад залруулах боломжтой 2,735.2 сая төгрөгийн алдааг залруулж, хохирлыг нөхөн төлүүлэхээр 7.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулахаар 2,303.5 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага, 1,046.0 сая төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлээ.


Үүнээс завсрын болон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжөөс нийт 3,014.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг ирүүлсэн байна.

(сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Дүн
1	Зөвлөмж хүргүүлсэн	1,046.0
2	Төлбөрийн акт тогтоосон	7.6
3	Албан шаардлага өгсөн	2,303.5
4	Залруулсан алдаа	2,735.2
	Дүн	6,092.3

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6 маягтад нэгтгэн хавсаргаж баримтжуулав.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүтцийг диаграммаар харуулбал:



2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэст улсын бүртгэлийн гэрчилгээгүй, байгууллагын статусгүй Засаг дарга гэсэн нэртэй дансаар сумдын малын тарилгын санхүүжилт, хөрөнгө оруулалтын зардлын гүйлгээ хийн санхүүгийн тайлан гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэж байгаа нь анхаарал татахуйц асуудал байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.34-т *“төсвийн байгууллага” гэж батлагдсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг/ заасныг зөрчиж байна.*

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn сайтад бүтэн жилээр нэг удаа оруулах мэдээлэл, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, дараа жилийн төсвийн төслийг PDF файлаар мэдээлсэн байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 2,873.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс хууль журам зөрчсөн 1,977.8 сая төгрөгийн материаллаг алдааг залруулах боломжгүй байна. Үүнээс 9.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 1,791,0 сая төгрөгийн албан шаардлага, 177.6 сая төгрөгийн зөвлөмжийг өгч, 895.6 сая төгрөгийн материаллаг бус алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн байна. Өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж хэрэгжилтийг албан бичгээр ирүүлсэн.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ОЮУНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Б.ГАНТУЯА

АУДИТОР

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ШИНЖЭЭЧ

Ж.УГТАХБАЯР

С.ЖАЛБАА

Огноо: 2016.04.20



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/7

Мандалговь

**Аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалын 9, 11, 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан /ДУАГ-2017/1-СТА-ТЕЗ/-г баталсугай.


2. Аудитаар илэрсэн зөрчил, акт, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. "Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 06 дугаар сарын 20-ны дотор Аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/, ерөнхий санхүүч /С.Энхжаргал/-нарт тус тус зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 3 дугаар улиралд гарган танилцуулахыг Аудитын менежер /Х.Наранцацрал/, санхүүгийн аудитын багийн ахлах аудитор /Б.Гантуяа/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ОЮУНЧИМЭГ

D:\office\Tushaal\A4\Batalgaajuulakh.docx

0000000022

Зөрчлийн нэгтгэл

Хавсралт /мянган төгрөгөөр/

№	Тайлан	Аудитын дүгнэлт	Аудитаар илрүүлсэн	Нийт алдаа	Үүнээс:		Нийт зөрчил	Үүнээс:			Үүнээс:	
					Залруулсан	Залруулаагүй		Акт тавьсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмж өгсөн	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй
1	Аймгийн ЗДТГ	Зөрчилгүй	-	-			-					-
2	Аймгийн ИТХ	Зөрчилгүй	206,322.6	206,322.6	206,322.6		-				206,322.6	-
3	Номын сан	Зөрчилгүй	2,184.9	578.8	578.8		1,606.1	797.6	124.5	684.0	578.8	1,606.1
4	Музей	Түүвэр	84.0	-			84.0			84.0		84.0
5	Нийгмийн халамж	Зөрчилгүй	1,451.7	1,451.7	1,451.7		-				1,451.7	-
6	ТТХТ	Итгэл үзүүлсэн	-	-			-					-
7	Байгаль орчны газар	Зөрчилгүй	-	-			-					-
8	Биеийн тамир спортын хороо	Зөрчилгүй	3,318.8	-			3,318.8			3,318.8		3,318.8
9	Ахмадын хороо	Зөрчилгүй	-	-			-					-
10	ГХБХБГ	Зөрчилгүй	-	-			-					-
11	Хот тохижилт	Зөрчилгүй	-	-			-					-
12	Сум дундын ойн анги	Зөрчилгүй	-	-			-					-
13	Боржигон мандал өрхийн эмнэлэг	Зөрчилгүй	-	-			-					-
14	Өлзийт мандал өрхийн эмнэлэг	Зөрчилгүй	-	-			-					-
15	ТХДЖТ	Зөрчилгүй	863.6	863.6	863.6		-				863.6	-
16	Санхүүгийн хяналт аудитын алба	Зөрчилгүй	123.4	123.4	123.4		-				123.4	-
17	Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	Зөрчилгүй	820.0	820.0	820.0		-				820.0	-
18	Орон нутгийн өмчийн газар	Зөрчилгүй	-	-			-					-
19	Тусгай зориулалтын сангууд	Түүвэр	-	-			-					-
20	Дэрэн ЭШТҮТөв	Зөрчилгүй	93,621.4	55,837.1	55,837.1		37,784.3			37,784.3	55,837.1	37,784.3
21	Дундговь Телевиз	Түүвэр	4,570.0	-			4,570.0			4,570.0		4,570.0
22	Дундговь-Ус	Зөрчилгүй	5,699.5	-	-		5,699.5			5,699.5	-	5,699.5
23	Нийтлэг үйлчилгээний алба	Зөрчилгүй	-	-			-					-
24	Хулд ЭЭС	Зөрчилгүй	34.2	34.2	34.2							34.2
25	Дэлгэрцогт	Зөрчилгүй	163,556.1	10,274.0	10,274.0		153,282.1	498.8	152,783.3		149,692.2	13,863.9
26	Дэрэн	Зөрчилгүй	176,515.5	4,844.3	4,844.2		171,671.2		169,377.7	2,293.5	176,515.5	-
27	Говь-Угтаал	Зөрчилгүй	63,293.0	13,965.6	13,965.6		49,327.4		5,695.1	43,632.3	61,975.4	1,317.6
28	Цагаандэлгэр	Зөрчилгүй	774,360.2	66,335.3	66,335.3		708,024.9		375,168.3	332,856.6	773,615.2	745.0
29	Баянжаргалан	Зөрчилгүй	228,800.8	957.8	957.8		227,843.0		172,086.0	55,757.0	227,893.2	907.6
30	Өндөршил	Зөрчилгүй	143,858.2	19,265.6	19,265.6		124,592.6	1,970.9	116,702.2	5,919.5	129,435.9	14,422.3
31	Гурвансайхан	Зөрчилгүй	2,137,430.3	1,889,011.3	1,889,011.3		248,419.0		233,447.0	14,972.0	2,113,469.9	23,960.4

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит

32	Өлзийт	Зөрчилгүй	637,208.6	48,675.6	48,675.6		588,533.1	2,041.1	130,296.3	456,195.7	580,198.3	57,010.3
33	Хулд	Зөрчилгүй	206,698.6	24,729.0	24,729.0		181,969.6	121.0	179,264.1	2,584.5	197,203.9	9,494.7
34	Луус	Зөрчилгүй	189,101.4	2,340.4	2,340.4		186,761.0		186,761.0		179,556.5	9,544.9
35	Дэлгэрхангай	Зөрчилгүй	180,372.7	6,864.4	6,864.4		173,508.3		162,137.0	11,371.3	161,169.1	19,203.6
36	Сайхан-Овоо	Зөрчилгүй	222,878.4	71,475.4	71,475.4		151,403.0	1,295.0	150,108.1		216,116.2	6,762.2
37	Эрдэнэдалай	Зөрчилгүй	148,508.0	25,196.1	25,196.1		123,311.9		66,057.2	57,254.7	32,654.9	115,853.1
38	Сайнцагаан	Зөрчилгүй	285,314.0	258,668.2	258,668.2		26,645.8	767.6	14,837.7	11,040.5	269,991.6	15,322.4
39	Адаацаг	Зөрчилгүй	215,317.6	26,580.8	26,580.8		188,736.8	145.0	188,591.8	-	213,918.1	1,399.5
Дүн			6,092,307.5	2,735,215.2	2,735,215.1	-	3,357,092.4	7,637.0	2,303,437.3	1,046,018.2	5,749,403.1	342,904.4

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж, санал тайлбарыг авлаа.


МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг.
Утас: 7059-3050. Факс: 7059-2895.
E-mail: info@dundgovi.gov.mn

2017.04.20 № 1/433
танай _____-ны № _____-т

Г ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ 7

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд танай 2017 оны 04-р сарын 14-ны өдрийн 63 тоотойр ирүүлсэн менежментийн захидалд санал тайлбар байхгүй болно

ЗАСАГ ДАРГА  Ө.БАТ-ЭРДЭНЭ

*Танилцуулж
Маймаг агуулах
14/20*

0200274